




СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ


- 1.1. Энэхүү журмын зорилго нь **“ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ” ХХК** (цаашид “Компани” гэх)-ийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх, илрүүлэх, удирдах үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.
- 1.2. Ашиг сонирхлын зөрчил гэж Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал болон Компанийн ажилтан албаны эрх, үүргээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол компанийн ашиг сонирхолтой зөрчилдөх, албан үүргээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг ойлгоно.
- 1.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон Компанийн ажилтан хууль дээдлэх зарчимд захирагдан, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлаас зайлсхийх үүрэгтэй.
- 1.4. Энэ журамд Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр өөрчлөлт оруулна.

ХОЁР. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛЭЙГ МЭДЭЭЛЛЭХ

- 2.1 ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн тухайн асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө энэ тухай ТУЗ-ийн даргад мэдэгдэж саналын эрхгүй оролцох бөгөөд хурлын тэмдэглэлд тусгана.
- 2.2 Компанитай хамтран ажиллах хүсэлт гаргасан компанитай ашиг сонирхлын зөрчилтэй Компанийн ажилтан нь энэ тухайгаа Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх бөгөөд тухайн ажлын хэсэгт орохгүй.
- 2.3 Компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор ашиг сонирхлын гэрээ, хэлцэл хийгдэх, шийдвэр гаргах нөхцөл үүссэн тохиолдолд Гүйцэтгэх захирал энэ тухай ТУЗ-д мэдэгдэж холбогдох шийдвэрийг гаргуулна.
- 2.4 Компанийн ажилтан албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд энэ тухай нэн даруй Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх үүрэгтэй.

ГУРАВ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛЭЙГ УДИРДАХ

- 3.1 Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал гарсан тохиолдолд ажилтны мэдүүлгийг үндэслэн Гүйцэтгэх захирал тухайн ажилтны гүйцэтгэх ажил үүргийг өөр ажилтанд шилжүүлэх арга хэмжээг авна.
- 3.2 Дараах тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно. Үүнд:




- 3.2.1 Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, өөр албан тушаалтан томилон ажилуулах боломжгүй;
- 3.2.2 Тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа;
- 3.2.3. Сонирхлын зөрчил үүссэн талаараа ажилтан Гүйцэтгэх захиралд мэдэгдсэн боловч тухайн асуудлыг компанийн дүрэм журмын хүрээнд шударгаар шийдвэрлэж чадна гэж Гүйцэтгэх захирал үзсэн;
- 3.3 Энэ журмын 3.2-т заасан нөхцөл бий болсон тохиолдолд энэ тухай ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ийн даргад нэн даруй мэдэгдэнэ.

ДӨРӨВ.АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ХЯНАХ, ИЛРҮҮЛЭХ

- 4.1 Ашиг сонирхлын зөрчилд хяналт тавих, илрүүлэх ажлыг Компанийн дотоод хяналт шалгалтын нэгж хэрэгжүүлнэ.
- 4.2 Компанийн дотоод хяналт шалгалтын нэгж, эсхүл энэ чиг үүргийг хэрэгжүүлэгч мэргэжилтэн нь ТУЗ-ийн гишүүн болон Компанийн ажилтнаас тэдэнтэй хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг Хавсралт 1-ийн дагуу гаргуулан мэдээллийн сан бүрдүүлнэ.
- 4.3 Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийн санг үндэслэн Компанийн дотоод хяналт шалгалтын нэгж эсхүл энэ чиг үүргийг хэрэгжүүлэгч мэргэжилтэн холбогдох албатай хамтран компанийн үндсэн үйл ажиллагаанд хяналт тавина.
- 4.4 Хяналт шалгалтын үеэр илэрсэн ашиг сонирхлын зөрчлийн тухай ТУЗ болон Гүйцэтгэх захиралд мэдэгдэнэ.

ТАВ.АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- 5.1 Компанийн ажилтан нь сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.
- 5.2 Компанийн дотоод хяналт шалгалтын нэгж эсхүл энэ чиг үүргийг хэрэгжүүлэгч мэргэжилтэн нь ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, хянах зорилгоор дараах ажлыг зохион байгуулна. Үүнд:
- 5.2.1 Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах талаар зөвлөмж өгөх;
- 5.2.2 Ашиг сонирхлын зөрчил, түүний агуулга, хор хохирлын талаар ажилтнуудад мэдээлэл,
- 5.2.3 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах;




5.2.4 Ажилтнуудаар нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн мэдээллийг жил тутамд шинэчилэн гаргуулж, байнга хяналт тавих.

ЗУРГАА.ХАРИУЦЛАГА

- 6.1. Ажилтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.
- 6.2. Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал гарсан тухай мэдээлээгүй, ашиг сонирхлын зөрчил үүссэнийг санаатайгаар нуун дарагдуулсан нь нотлогдвол буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ” ХХК



КОМПАНИЙН АЖИЛТНУУДЫН ХАМААРАЛ БҮХИЙ БОЛОН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН МЭДҮҮЛГИЙН ХУУДАС

Ажилтны овог нэр:

Албан тушаал:

Ажилд томилогдсон огноо:

Ажилтантай хамаарал бүхий этгээд:

Д/д	Эцэг /эх/ -ийн нэр, нэр	Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Ямар хамааралтай эсэх

Тайлбар: Компанийн үйл ажиллагааны хүрээнд шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүсийн талаар бичнэ.

Ажилтантай нэгдмэл сонирхолтой этгээд:

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь, хүн хуулийн этгээлдийн нэр	Ямар харилцаатай /байсан/ болох /хуулийн этгээдэд бол ямар хамааралтай болох/	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Байгууллага, ажил, албан тушаал /Эрхэлж байгаа/ байсан/ үйл ажиллагааны төрөл	Тайлбар

Тайлбар: Ажилтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ.

“ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ” ХХК